**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 27 өдөр | Дугаар 11 | Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.12 дахь заалт, Үндэсний аудитын газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07/537 тоот дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаар дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн а/774 дүгээр удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дулаан шарын гол” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас ирүүлсэн “Өөрчлөлтгүй” дүгнэлтэй танилцан, аудитаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангах, зөрчлийг арилгуулах талаар хэлэлцэв.

2.Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Ж.Даш/ нарт үүрэг болгосугай.

3.Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Даваадорж/, гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/ нарт даалгасугай.

ДАРГА П.ДАВААДОРЖ

# ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 27 өдөр Дугаар 12 Улаанбаатар хот

## Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх түр журам”, Эрчим хүчний сайдын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн а/775 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг 91 оноогоор “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт, дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Даваадорж/, гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/ нарт даалгасугай.

ДАРГА П.ДАВААДОРЖ

Дулаан Шарын гол ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хурлын ... дугаар тогтоолын хавсралт

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Дүгнэх үзүүлэлт | хэмжих нэгж | 2021 оны гүйц | 2022 он | | | | Дулаан дамжуулах, түгээх сүлжээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөв | гүйц | зөрүү | хувь | Авбал зохих оноо | Авсан оноо |
| 1 | **Эдийн засгийн үзүүлэлт** | | | | | | | **50** | **42.7** |
| 1.1 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | | | | | | | 5 | 4.7 |
| | а. ДЭХ-ний үйлдвэрлэлт | мян. гкал | 38.8 | 39.1 | 38.2 | (0.9) | 97.8 | 5 | 4 |
| | б. Цэвэр ус олборлолт | мян.м3 | 306.8 | 315.4 | 300.0 | (15.4) | 95.1 | 5 | 5 |
| | в. Бохир ус татан зайлуулалт | мян.м3 | 232.2 | 277.4 | 247.8 | (29.6) | 89.3 | 5 | 5 |
| 1.2 | Нийт орлого | сая.төг | 3,032.1 | 3,537.4 | 3,590.4 | 53.0 | 101.5 | 5 | 5 |
| 1.3 | Нийт зардал | сая.төг | 3,216.8 | 3,962.3 | 3,637.4 | (324.8) | 91.8 | 5 | 5 |
| 1.4 | Цэвэр ашиг алдагдал | сая.төг | (184.7) | (424.9) | (47.0) | 377.8 | 11.1 | 10 | 10 |
| 1.5 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | | 1.35 | 1.37 | 1.29 | (0.08) | 94.2 | 5 | 5 |
| 1.6 | Нийт авлага | сая.төг | 433.7 | 100.5 | 223.8 | 123.3 | 222.6 | 5 | 4 |
| 1.7 | Нийт өглөг | сая.төг | 1,819.6 | 1,258.4 | 1,335.0 | 76.5 | 106.1 | 5 | 4 |
| 1.8 | Хөрөнгө оруулалт, ТЗБАХ, их засварын ажлын биелэлт | сая.төг | 94.7 | 120.8 | 118.4 | (2.5) | 98.0 | 5 | 5 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9 | Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх | | | | | | | 5 | - |
| **2** | **Тайлангийн үр дүн** | | | | | | | **25** | **23** |
| 2.1 | Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт | | | | | | | 6 | 5 |
| 2.2 | Захирлын ажлын тайлан | | | | | | | 2 | 2 |
| 2.3 | Шийдвэрийн хэрэгжилт /ЭХЯ, ТӨБЗГ/ | | | | | | | 5 | 5 |
| 2.4 | Худалдан авах ажиллагааны тухай хууль, Шилэн дансны хууль болон бусад хууль тогтоомжийн биелэлт | | | | | | | 5 | 4 |
| 2.5 | Хэрэглэгчийн санал асуулгын дүн | | | | | | | 3 | 3 |
| 2.6 | Ажилтнуудын санал асуулгын дүн | | | | | | | 4 | 4 |
| **3** | **Техникийн үзүүлэлт** | | | | | | | **25** | **25** |
| 3.4 | Нэмэлт усны зарцуулалт урд оны мөн үеийнхээс /+,-/ | мян.м3 | 19.33 | 23.4 | 22.11 | (1.3) | 94.5 | 10 | 10 |
| 3.6 | Үйлдвэрлэлийн осол, авaарь,1,2 дугаар зэргийн саатал | тоо | | | | | | 15 | 15 |
| | **НИЙТ ДҮН** | | | | | | | **100** | **91** |